



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Халамжийн сангийн /Орон нутаг/ 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /3/ НА-СТА-ОНТС

Цахим хуудас:

www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор:Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	8
4. Аудитын илрүүлэлт.....	9
4.1 Зөвлөмж	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 19

танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Х.ЭРДЭНЭБАТ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Халамжийн сангийн /Орон нутаг/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Халамжийн сангийн /Орон нутаг/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,901,300.00	0.00
33	АВЛАГА	4,901,300.00	0.00
335	Бусад авлага	4,901,300.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	4,901,300.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,901,300.00	0.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,901,300.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,901,300.00	0.00
413	Өглөг	4,901,300.00	0.00
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	4,901,300.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,901,300.00	0.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	128,496,326.06	128,380,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,326.06	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	116,326.06	0.00
120002	Хүүгийн орлого	116,326.06	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	128,380,000.00	128,380,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,380,000.00	128,380,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,380,000.00	128,380,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	128,496,326.06	128,380,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	128,496,326.06	128,380,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,496,326.06	128,380,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,924,000.00	119,595,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	103,924,000.00	119,595,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,572,326.06	8,785,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,572,326.06	8,785,000.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	128,496,326.06	128,380,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,326.06	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	116,326.06	0.00
120002	Хүүгийн орлого	116,326.06	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	128,380,000.00	128,380,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,380,000.00	128,380,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,380,000.00	128,380,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	128,496,326.06	128,380,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	128,496,326.06	128,380,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,496,326.06	128,380,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,924,000.00	119,595,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	103,924,000.00	119,595,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,572,326.06	8,785,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,572,326.06	8,785,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	128,380,000.00	119,595,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	128,380,000.00	119,595,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,380,000.00	119,595,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,380,000.00	119,595,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	128,380,000.00	119,595,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	128,380,000.00	119,595,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,380,000.00	119,595,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	128,380,000.00	119,595,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Орон нутгийн тусгай сан тул нэмэлт төсвийн дансгүй болно.



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/ 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01/114 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/ үйл ажиллагааны чиглэлийг Нийгмийн халамжийн тухай хуулиар тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/ 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **дунд** гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 128,380.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,283.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 898.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Халамжийн сангийн /Орон нутаг/ 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд өмнөх оны авлага, өглөгийн үлдэгдлийг бүрэн барагдуулж нийт хөрөнгө 0 төгрөгөөр тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	4,901.3	0	0
Эргэлтийн бус хөрөнгө			
Нийт хөрөнгө	4,901.3	0	-4,901.3
Өр төлбөр	4,901.3		
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,901.3	0	-4,901.3

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 128,380.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 128,380.1 мянган төгрөгөөр тооцон баталж төсвийн хуваарь ирүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71902 /Нийгмийн халамж/ хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 128,380.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 128,380.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 128,380.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 75,195.0 мянган төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 44,400.0 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 8,785.0 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн Халамжийн сангийн /Орон нутаг/ санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/ нь шилэн дансны нэгдсэн системд тусдаа цэсгүй байна. Халамжийн сангийн /Улсын төсөв/ Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийг бүрэн хугацаанд нь оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл үзүүлсэн” байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/ санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.



4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Зардлын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/-аас 2021 оны 04-р сард Орхон аймгийн Баян-Өндөр сумын Оюут багийн 2-4-53 тоотод оршин суух хаягтай 69 настай иргэн Ж.Товууд /ФМ52021411/ Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1-д заасан /онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж/ тэтгэмжид 1,200.0 мянган төгрөг олгосон байна. Иргэн Ж.Товуугийн улсын бүртгэлийн хаяг дахь 2-4-53 тоот орон байранд Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1-д заасан гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй болсон тохиолдол бий болоогүй бөгөөд уг иргэний байнга оршин суудаг гэх Булган аймгийн Орхон сумын Халиун багийн /2-р баг/ нутаг Ар мэргэнд байрлах 000064486 дугаарын эзэмших гэрчилгээтэй зуслангийн газар дээр баригдсан байшинд гал гарч анх харсан иргэн Н.Даваадоржийн 2021.01.05-ны 08:52 цагт өгсөн дуудлагаар Онцгой байдлын газраас очиж унтраажээ.

Эндээс улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй 2-4-53 тоот хаягт оршин суух Орхон аймгийн иргэнд /Иргэний хуулийн 22.1-д "Иргэний оршин суугаа газрын хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно"/ гэнэтийн гэр оронгүй болох аюул, осол тохиолдоогүй бөгөөд харин Булган аймгийн иргэн Ж.Товууд /Иргэний хуулийн 22.2-д "Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно"/ Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1-д заасан тохиолдол үүссэн гэж үзэхээр байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/129 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дүрэм"-ын 2.1-д "Газар нь ... үйлчилгээг үр ашигтай, шуурхай хүргэх үүргийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хүлээнэ", 2.2-д "Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр, халамжийн асуудлаар иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлж, ... хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иргэн Ж.Товуугийн хувьд Ар мэргэндээ байнга оршин суудаг бол шилжилт хөдөлгөөнөө хийлгэх байсан. Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 14.2-д "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй", 6.1.13-д "шилжилт хөдөлгөөний", Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18.2-д "Иргэний 180 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа газрын хаяг нь энэ хуулийн 19.1-д заасны дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна", 19.1-д "Иргэн шилжин суурьшихдаа дараах баримт бичгийг бүрдүүлж, оршин суух газрынхаа /сум, хорооны/ улсын бүртгэгчид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/129 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дүрэм"-ын 2.1, 2.2-д заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын код: ОРА-2022 /3/ НА-СТА-ОНТС



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Орхон аймгийн Халамжийн сан /Орон нутаг/	1	1,200.0							1	1,200.0
Дүн		1	1,200.0							1	1,200.0